

**“МАНЖИЙН ҮНЭН МАГАД ХУУЛЬ” (MANJU YARGIYAN
QQOLI) ЗОХИОЛ ДАХЬ МАНЖ ХЭЛНИЙ БИЕЭР ТӨГСГӨХ
НӨХЦӨЛИЙН УТГЫН ХУВИЛБАРУУД**

Э.Эрдэнэзуу*

Товч агуулга: Манжийн үнэн магад хуулийг Сэцэн хааны тэргүүн он (1627)-оос эхлэн найруулж, Сэцэн хааны 9-р он (1635) онд бичиж дуусгаснаас хойш хэд хэдэн удаа сэлбэн засаж, улмаар Тэнгэрийн тэтгэсэний 46-р он (1781)-д манж-хятад-монгол гурван үсгээр хадмаллаж, байлдах зураг сэлтийг хавсарган нийт 8 дэвтэр болгон барлан тархаажээ. Бид энэхүү өгүүлэлдээ уг бар хэвлэлийг эш болгон, манж хэлний биеэр төгсөх нөхцөлүүдийг монгол хэлнээ хэрхэн орчуулсан талаар өгүүлэх болно.

Түлхүүр үг: Магад хууль, манж хэл, монгол хэл, биеэр төгсөх нөхцөл

**Нэг. Манжийн Магад хууль зохиол дахь манж хэлний нэгдүгээр биеэр
төгсгөх “-ki” нөхцөлийн утгын хувилбарууд**

1.1. Манж хэлний нэгдүгээр биеийн шийдэн хүсэх **-ki** нөхцөлийг монгол хэлний **-у-а/ -у-е** нөхцөлөөр орчуулсан нь:

Man. tondo sain niyalma oči ton-de dosimbufi doro-de aisilabuki¹

Mon. ünen sedkil-tü kümün bolbasu tegün-i abču törü-tür tüsigülüy-e.
Үнэнхүү сэтгэлт хүн болбоос түүнийг авч төрд түшүүлье (МҮӨ:
181).

Man. sarin-de baitangya niyalma oči sarin-de baitalaki

Mon. qurim-tur kereg-tür kümün bolbasu qurim-un yabudal-tur kergeley-
e. Хуримд хэрэгт хүн болбоос хуримын явдалд хэрэглэе (МҮӨ:
181).

* ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Харьцуулсан хэл шинжлэлийн салбарын эрдэм шинжилгээний ажилтан, магистр. erdenezuu@mas.ac.mn

¹ МУИС-ийн манж хэлний сургалт, судалгаанд баримталж ирсэн галиг.

1.2. Манж хэлний нэгдүгээр биеийн шийдэн хүсэх **-ki** нөхцөлийг монгол хэлний **-suyai/ -sügei** нөхцөлөөр орчуулсан нь:

- Man. wan han-de čooha baiki seme hendufi
 Мон. wan qaγan-ača. bi čerig γuyusuyai kemen ögüleged. Ван хаанаас би цэрэг гуйсугай хэмээн өгүүлээд (MYQ: 16).
 Man. omolo saryan jui-be tučibufi γajiki seči
 Мон. ači ökin-iyen abču γarsuyai kemebesü. Ач охиноо авч гарсугай хэмээвээс (MYQ: 27).
 Man. niqan wailan-de dahaki seme
 Мон. niqan wayilan-tur urbasuyai kemeldüged. Никан Вайланд урвасугай хэмээлдээд (MYQ: 30).

1.3. Манж хэлний нэгдүгээр биеийн шийдэн хүсэх **-ki** нөхцөлийг монгол хэлний **-tuyai/ -tügei** нөхцөлөөр орчуулсан нь:

- Man. dabaha niyalma-be saha niyalma waki
 Мон. dababasu tere kümün-i ken üjebesü alaturyai. Давбаас тэр хүнийг хэн үзвээс алтурай (MYQ: 139).

1.4. Манж хэлний нэгдүгээр биеийн шийдэн хүсэх **-ki** нөхцөлийг монгол хэлний **-ju/ -jü** нөхцөлөөр орчуулсан нь:

- Man. muse gurun-de ejen ojoro-be temšerengge naqaki
 Мон. bide ber ulus-tur-iyen ejen bolqu-yi temečeldüküi-ben bayju. Бид бээр улсдаа эзэн болохыг тэмцэлдэхээ байж (MYQ: 07).
 Man. ere sinde-de musei gurun-be neneme bargiyaki. babe bekileme
 Мон. ene čölügen-tür ulus-iyen quriyaju. γajar-iyen batulan. Энэ чөлөөнд улсаа хурааж, газраа батлан (MYQ: 178).

1.5. Манж хэлний нэгдүгээр биеийн шийдэн хүсэх **-ki+se-** нийлцийг монгол хэлний **-y-a/ -y-e** нөхцөлөөр орчуулсан нь:

- Man. ahana wejige yabuki sehe saryan jui-be mini jui γaiha.
 Мон. aqan-a-yin süyiley-e kemegsen ökin-i köbegün minu abču bölüge. Аханагийн сүйлье хэмээсэн охиныг хөвгүүн минь авч бүлгээ (MYQ: 14).
 Man. taizu sure beile-be waki seme
 Мон. tayisu sečen noyan-i maγu sedkiy-e kemen. Тайзү сэцэн ноёныг муу сэтгэе хэмээн (MYQ: 37).
 Man. emu γašan-de ačafi teki seme gisureme
 Мон. nigen γajar-a čuylaju saγuy-a kemen ögüeldüjü. Нэгэн газраа цуглаж сууя хэмээн өгүүлэлдэж (MYQ: 16).
 Man. bardai hoton-be dailaki seme čooha genefi
 Мон. barda-yin qota-yi daγuliy-a kemen čerig morilaju. Бардай хотыг

дайлья хэмээн цэрэг морилж (MYQ: 35).

1.5.1.1 Манж хэлний нэгдүгээр биеийн шийдэн хүсэх **-ki+seme** нийлцийг монгол хэлний **-qu ajiyamu/ -kü ajiyamu** -аар орчуулсан нь:

Man. mini batangya ongyoloi niyalma-be efuleki seme baiha manggi.

Mon. nadur ösiy-e-tü ongyolo-yin kümün-i ebdekü **ajiayamu** kemen guyubasu. Надад өшөөт Онгологийн хүнийг эвдэх **ажааму** хэмээн гуйваас (MYQ: 50).

1.5.1.2. Манж хэлний нэгдүгээр биеийн шийдэн хүсэх **-ki+seme** нийлцийг монгол хэлний **-dqun/ -dkün** -ээр орчуулсан нь:

Man. čooha naqaki seme tafulači

Mon. čerig morilaqu-yi bayidqun kemen idqabasu. Цэрэг морилбоос **байдхун** хэмээн ятгаваас.

1.5.2.1. Манж хэлний нэгдүгээр биеийн шийдэн хүсэх **-ki+sere+de** нийлцийг монгол хэлний **-qui+dur/ -küi+dür** -ээр орчуулсан нь:

Man. nesin-be sačiki sere-de

Mon. nesin-i čabčiqui-tur. Нэшинийг цавчихуйд (MYQ: 56).

Man. etuku etuki sere-de

Mon. degel qubčad-iyen qubčalaqui jayur-a. Дээл хувцдаа хувцлахуй зуур (MYQ: 04).

Man. si šusihiyefi ʒajifi mini čooha qokiraha seme jafaki sere-de

Mon. či oduju abču ireged čerig minu qorumji bolbai kemen ögülejü bariqui-tur. Чи одож авч ирээд, цэрэг минь хоромж болов хэмээн өгүүлж барихуйд (MYQ: 28).

1.5.2.2. Манж хэлний нэгдүгээр биеийн шийдэн хүсэх **-ki+sere+de** нийлцийг монгол хэлний **-ju+tal-a/ -jü tel-e** -ээр орчуулсан нь:

Man. hülha wan sindafi tafuki sere-de

Mon. qulayaüičid šatu talbiyad dabaju ʒartala. Хулгайчид шат тавиад **давж гаргал** (MYQ: 57).

1.5.2.3. Манж хэлний нэгдүгээр биеийн шийдэн хүсэх **-ki+sere+de** нийлцийг монгол хэлний **-n+qui+dur / qui+dur** -аар орчуулсан нь:

Man. Bujantai beile ambula ʒolofi teni burulaki serede

Mon. Bujantai noyan yekede ayuyad dutayaqui-tur. Бүжантай бэйл ихэд айгаад дутаахуйд.

Man. gidai toqoki serede.

Mon. jida-bar qadqun jabduqui-dur. Жадаар хадган завдахуйд (MYQ: 77).

1.5.3.1. Манж хэлний нэгдүгээр биеийн шийдэн хүсэх **-ki+seči** нийлцийг монгол хэлний **-qu+bögesü** -ээр орчуулсан нь:

Man. minde buki **seči**.

Mon. nadur ögkü bögesü. Надад өгөх **бөгөөс** (MYQ: 73).

1.5.3.2. Манж хэлний нэгдүгээр биеийн шийдэн хүсэх **-ki+seči** нийлцийг монгол хэлний **-n+jabdubasu** -аар орчуулсан нь:

Man. bi emu niyalma-be bahafi waki **seči**

Mon. bi nigen kümün-i bariju alan **jabdubasu**. Би нэгэн хүнийг барьж алан **завдваас** (MYQ: 98).

1.5.4. Манж хэлний нэгдүгээр биеийн шийдэн хүсэх **-ki+sembio** нийлцийг монгол хэлний **-qu+buyu** -аар орчуулсан нь:

Man. wahai dele wačihiyame waki **sembio seme**

Mon. alaysan-u deger-e bas-a **alaqu buyu kemen**. Алсны дээр бас алах **буюу хэмээн** (MYQ: 57).

1.5.5. Манж хэлний нэгдүгээр биеийн шийдэн хүсэх **-ki+sehe manggi** нийлцийг монгол хэлний **-y+a/ -y-e+хэмээвээс** -ээр орчуулсан нь:

Man. bidhe-be tuwaki **sehe manggi**

Mon. bičig-i inu üjey-**e kemebesü**. Бичгийг нь үзье **хэмээвээс** (MYQ: 81).

Man. beise ambasa dahûn dahûn-i marame čooaha **geneki sehe manggi**

Mon. noyad sayid ded ded-iyer jidküjü čerig morily-**a kemebesü**. Ноёд сайд дэд дэдээр зүтгэж, цэрэг морилья **хэмээвээс** (MYQ: 176).

1.5.6. Манж хэлний нэгдүгээр биеийн шийдэн хүсэх **-ki+dere seme** нийлцийг монгол хэлний **-ydaqui/ -gdeküi** -ээр орчуулсан нь:

Man. udhai tukiye**ki dere seme** henduhe

Mon. üdter böged ergü**gdeküi** kemen jarlay bolbai. Үтэр бөгөөд өргөгдөхүй хэмээн зарлиг болов (MYQ: 180).

1.5.7. Манж хэлний нэгдүгээр биеийн шийдэн хүсэх **-ki+ čina seme** нийлцийг монгол хэлний **-y-a la / -y-e le** -ээр орчуулсан нь:

Man. abalaki yabu**čina seme**

Mon. abalay**ala kemeldükü-yi**. Авлая л хэмээлдэхийг (MYQ: 180).

1.5.8. Манж хэлний нэгдүгээр биеийн шийдэн хүсэх **-ki+ dere** нийлцийг монгол хэлний **-y-a/ -y-e** -ээр орчуулсан нь:

Man. sain niyalma ambula oči teisu teisu baita-de afabuki **dere**

Mon. sayin kümün olan bolbasu. jüyil jüyil-iyer keregten üyiles-tür

tüsigülüy-e. Сайн хүн олон болбоос зүйл зүйлээр хэрэгтэн үйлсэд түшүүлье (МҮQ: 181).

Тус сурвалжид манж хэлний -ki нөхцөлийг монгол хэлний -su/ -sü нөхцөлөөр орчуулсан жишээ үл тохиолдож буй нь сонирхолтой юм. Манж хэлний нэгдүгээр биеэр төгсгөх “-ki” нөхцөлийг тус сурвалжид хэрхэн орчуулсныг нэгтгэвэл:

Man	Mon	
-ki	-y-a/ -y-e	-я, -е, -ё
	-suγai/ -sügei	-сугай/ -сүгэй
	-tuγai/ -tügei	-тугай/ -түгэй
	-ju/ -jü	-ж, -ч
-ki sehe	-y-a/ -y-e	-я, -е, -ё
-ki seme	-qu ajiyamu/ -kü ajiyamu	-х ажааму
	-dqun/ -dkün	-дхун/ -дхүн
-ki sere-de	-qui+dur/ -küi+dür	-хуйд/ -хүйд
	-ju+tal-a/ -jü tel-e	-ж тал ⁴
	-n+qui+dur/ qui+dur	-н хуйд/ -н хүйд
-ki+seči	-qu+bögesü	-х бөгөөс
	-n+jabdubasu	-н завдваас
-ki+sembio	-qu+buyu	-х буюу
-ki+sehe manggi	-y+a / -y-e kemebesü	-я, -е, -ё хэмээвээс
-ki+ dere	-y-a/ -y-e	-я, -е, -ё
	-γdaqui/ -gdeküi	-гдахуй/ -гдэхүй
-ki+ čina	-y-a la / -y-e le	-я, -е, -ё л

Хоёр. Манжийн Магад хууль зохиол дахь манж хэлний хоёрдугаар биеэр төгсгөх нөхцөлийн утгын хувилбарууд

2.1.1. Манж хэлний хоёрдугаар биеийн **-ra/-re** нөхцөлийг монгол хэлний **-suγai/ -sügei** -ээр орчуулсан нь:

Man. suwe afaraqû oči. be juleri afara

Mon. ta es-e qadquldubasu bide urida qadquldusuyai. Та эс хатгалдваас бид урьд хатгалдсугай (МҮQ: 35).

Man. etu arui uyun tulaha-be γaifi minde γaji bi fonjire

Mon. etü arü-yin yisün qulayayüicid-i bariju nadur аса. bi tegün-eče asaγusuyai. Этү, Арүгийн есөн хулгайчдыг барьж надад ац. Би түүнээс асуусугай (МҮQ: 15).

Man. yehe-be dailaraqû oči mimbe dere banime naqaha seme γünire

Mon. yekege-yin ulus-i es-e dayilabasu. minu tala-tur bayiba kemen sedkisügei. Ехэгийн улсыг эс дайлбаас миний талд байв хэмээн сэтгэсүгэй (МҮQ: 167).

2.1.2. Манж хэлний хоёрдугаар биеийн **-ra/-re** нөхцөлийг монгол хэлний **-dqun/ -dkün** -ээр орчуулсан нь:

Man. si hunehe aiman-i hanggiyai yolo. jaqûmui yolo-be ume neçire.

Mon. çi küneke-yin ayimaγ-un qanggiya-yin yool. jaqamu-yin yool qoyar-i büü könded**dkün**. Чи Хүнэхэгийн аймгийн Хангиягийн гол, Жакумугийн гол хоёрыг бүү хөндөдхүн (МҮQ: 34).

Man. si ume genere

Mon. çi büü odud**qun**. Чи бүү ододхун (МҮQ: 42).

Man. suweni çaiha. fanaha. sançara ere ilan yoloï tariha jeku-be ume çaijara

Mon. ta çayiq-a. fanaq-a. sançar-a ene yurban yool-un tariγsan tariγ-a-ban büü abud**qun**. Та Цайха, Фанаха, Санчара энэ гурван голын тарьсан тариагаа бүү авадхун (МҮQ: 173).

2.1.3. Манж хэлний хоёрдугаар биеийн **-ra/-re** нөхцөлийг монгол хэлний **-γdaqui/ -gdeküi** -ээр орчуулсан нь:

Man. fulehe-be ume tuwara

Mon. iγayur-i inu ülü sinjileg**deküi**. Язгуурыг нь үл шинжлэгдэхүй (МҮQ: 179).

Man. giran-be ume tuwara

Mon. törül-i inu ülü üjeg**deküi**. Төрлийг нь үл үзэгдэхүй (МҮQ: 179).

Man. ulin-be ume γünire

Mon. ed tawar-iyan ülü sanaγ**daqui**. Эд таваараа үл санагдахүй (МҮQ: 181).

2.1.4. Манж хэлний хоёрдугаар биеийн **-ra/-re** нөхцөлийг монгол хэлний **-mu/ -mü** -ээр орчуулсан нь:

Man. buya qoro-be ya-be hendure

Mon. öçükem ösiyen-i inu alin-i toγalamu. Өчүүхэн өшөөг нь алиныг тоолму.

2.1.5. Манж хэлний хоёрдугаар биеийн **-ra/-re** + **sehe manggi** нийлцийг монгол хэлний **-mui/ -müi** -ээр орчуулсан нь:

Man. mini beye kuşun ohobi. adarame tutara sehe manggi

Mon. köl minu kündü bolba. ta qoyar-aça anggida yaqin qoçormui bi. Хөл минь хүнд болов. Та хоёроос ангид яахан хоцормуй би (МҮQ: 4).

2.1.6. Манж хэлний хоёрдугаар биеийн **-rau/-reu/-roo** нийлцийг монгол

хэлний **-mu uu/ -mü üü** -ээр орчуулсан нь:

- Man. labtai si mini loho-be alime γaime mutereu seme henduhe manggi
 Mon. labtai či ildün-tür minu tesčü bayimu uu kemen jarlay bolbasu. Лавтай чи илдэнд минь тэсэж байму юу хэмээн зарлиг болбоос (MYQ: 154).
 Man. abqa čembe waqalarau seme γünimbi qai seme hendufi
 Mon. tngri teden-i buruγu üjemü j-a. kemen jarlay boluγad. Тэнгэр тэднийг буруу үзмү за хэмээн зарлиг болоод (MYQ: 91).

2.1.7.1. Манж хэлний хоёрдугаар биеийн **-rahû** нөхцөлийг монгол хэлний **-uyujai/ -güjei** -ээр орчуулсан нь:

- Man. taizu sure beile hendume. suwe ume jidere bata sererahû
 Mon. taisu sečen noyan jarlay bolor-un. ta büü iredkün dayisun kümün seregüjei. Тайзү сэцэн ноён зарлиг болруун: Та бүү ирэдхүн, айсан хүн сэргүүзэй (MYQ: 52).
 Man. taizu sure beile bata-be saburahû seme
 Mon. taisu sečen noyan dayisun kümün-i üjegüjei kemen. Тайзү сэцэн ноён дайсан хүнийг үзүүзэй хэмээн (MYQ: 61).

2.1.7.2. Манж хэлний хоёрдугаар биеийн **-rahû** нөхцөлийг монгол хэлний **-qu uu-** аар орчуулсан нь:

- Man. warahû seme gelembidere
 Mon. alaqu bolbayuu kemen emiyen ayuγu sedkimü y-e. Алах болов уу хэмээн эмээн айж сэтгэмү зэ (MYQ: 280).

2.2.1. Манж хэлний хоёрдугаар биеийн **-čina** нөхцөлийг монгол хэлний **-dqun/ -dkün-**ээр орчуулсан нь:

- Man. mimbe emu dain-de juleri afabume tuwačina sehe manggi.
 Mon. namayi nigecken ber dayisun-tur manglayilan qadqulduγulju mededkün kemen ayiladqabas. Намайг нэгээхэн бээр дайсныг манлайлан хатгалдуулж мэдэдхүн хэмээн айлтгаваас (MYQ: 114).
 Man. eme-be γanafu taqabume tuwačina sehe manggi
 Mon. eke-yi inu abču ireged. taniγuludqun kemebesü. Эхийг нь авч ирээд таниуладхун хэмээвээс (MYQ: 276).

2.2.2. Манж хэлний хоёрдугаар биеийн **-čina** нөхцөлийг монгол хэлний **-y-a/ -y-e** -ээр орчуулсан нь:

- Man. hoton hečen-be efuleme afačina.
 Mon. qota baγad-i ebdejü qadqulduy-a bide. Хот балгадыг эвдэж хатгалдъя бид.

2.2.2. Манж хэлний хоёрдугаар биеийн **-čina** нөхцөлийг монгол хэлний **-qu bui y-a** -аар орчуулсан нь:

Man. suwe jafafi benjičina. ainu waha.

Mon. ta ber bariyad kürgejü irekü **bui j-a**. jaγun-u tulada alabai. Та бээр бариад хүргэж ирэх **буй за**. Юуны тулд алав (MYQ: 188).

2.2.3. Манж хэлний хоёрдугаар биеийн **-čina** нөхцөлийг утгачлан орчуулсан нь:

Man. mini jui ehe weile arači minde alanjičina.

Mon. ökin minu endejü aldabasu. nadur sonusqaju **ilyaju medekü bui j-a**. Охин минь эндэж алдваас надад сонсгож ялгаж мэдэхүй буй за (MYQ: 152).

Man. qorsoho ba biči emu niyalma-be elčín taqûrame fonjičina sehe manggi

Mon. kilinglegsen učir-iyan nigen kümün-i elči ilegejü asaγulya**qu ajiyamu**. Хилэгнэсэн учраа нэгэн хүнийг элч илгээж асуулгах **ажаму** (MYQ: 153).

Man. abalaki yabučina seme juwe nofi jendu gisurere-be

Mon. abalayala kemeldükü-yi. Авлая л хэмээлдэхийг (MYQ: 180).

Man	Mon	
-ra/-re	-suγai/ -sügei	-сугай/ -сүгэй
	-dqun/ -dkün	-дхун/ -дхүн
	-γdaqui/ -gdeküi	-гдахуй/ -гдэхүй
	-mu/ -mü	-му, -мү
-ra/-re + sehe manggi	-mui/ -müi	-муй, -мүй
-rau/-reu/-roo	-mu uu/ -mü üü	-му юу / -мү юү
-rahû	-γujai/ -güjei	-гуузай/ -гүүзэй
	-qu uu	-х уу/ -х үү
-čina	-dqun/ -dkün	-дхун/ -дхүн
	-y-a/ -y-e	-я, -е, -ё
	-qu bui y-a	-х буй за

Гурав. Манжийн Магад хууль зохиол дахь манж хэлний гуравдугаар биеэр төгсгөх нөхцөлийн утгын хувилбарууд

Манж хэлний гуравдугаар биед ерөөн хүсэх утга бүхий **-kini** нөхцөлийг монгол хэлний **-tuγai/ -tügei** нөхцөлөөр орчуулсан нь:

Man. jui simbe abqa fačuqûn gurun-be dasame banjikini seme banjubuhabi.

Mon. tngri čimayi manju ulus-un samayu törü-yi jasatuγai kemen

törügülügsen buyu. Тэнгэр чамайг Манж улсын самуу төрийг **застугай** хэмээн төрүүлсэн буюу (MҮQ: 05).

Man. manju aifuᠰi. manju-de ehe sui isikini

Mon. manju ulus ebdebesü manju ulus-tur nigül kürtügei. Манж улс эвдвээс Манж улсад нүгэл хүртүгэй (MҮQ: 139).

Man. bujantai si uru okini.

Mon. bujantai cinukei jöb boltuᠶai. Бүжантай чинийх зөв болтуᠶай. (MҮQ: 152)

Man	Mon	
-kini	-tuᠶai/ -tügei	-туᠶай/ -түгэй

Дүгнэлт

“Манжийн үнэн магад хууль” (Manjui yarıᠭuyan qooli) зохиолын монгол орчуулгад манж хэлний биеэр төгсөх нөхцөлүүдийг манж эхэд баригдалгүй ихэд чөлөөтэй орчуулжээ. Манж хэлний биеэр төгсөх нөхцөлүүдийг хэд хэдэн хэлбэрээр ийнхүү чөлөөтэй орчуулсан нь монгол бичгийн хэл манж бичгийн хэлнээс илүү өмнө боловсрон хөгжсөнийг батлахын сацуу “Манжийн үнэн магад хууль” зохиолын монгол орчуулга нь өгүүлэн буй бар хэвлэлээс он цагийн хувьд илүү өмнө орчуулагдаж (зохиолын үг хэллэгээс ажиглавал XVII зууны эхэн үе болов уу Э.Э) хуулбарлагдсаныг илтгэж байна.

Summary

“Veritable records of the Manchus” (man. manjui yargiyan qooli. chin. 滿洲實錄 manzhou shilu) was published in the 46th year (1781) of the Qianlong Emperor with subtitles in manchu, chinese, and mongolian scripts, attended by depiction and drawings, a total of 8 volume. In this paper, we will introduce about how the imperative mood in manchu language were translated into the mongolian version of that source.

Ном зүй

Manju yarıᠭuyan qooli. 滿洲實錄. Manju yarıᠭuyan qooli. Manju-yin ünén maᠶad qauli.

Баярсайхан М., Отгонтуул Т. (1997). *Монгол, манж толь*. Улаанбаатар: МУИС хэвлэл [Bayarsaikhan, M., Otgontuul, T. (1997). Mongolian-Manchu dictionary. Ulaanbaatar: NUM printing.]

Баярсайхан, М. (2022). Монгол, манж хэлний харьцаа. *Монгол хэл судлал*. IV. Ред. Д.Заяабаатар. Улаанбаатар. Х. 59-60. [Bayarsaikhan, M. (2022). Comparison of Mongolian and Manchu language. *Mongolian language studies*.


IV. Ed. Zayabaatar D. Ulaanbaatar. P. 59-60.]

Мижиддорж, Го. (1976). *Монгол, манж бичгийн хэлний харьцаа*. Улаанбаатар: Шинжлэх Ухааны Академийн Хэвлэл. [Mijiddorj, Go. (1976). *Comparison of Mongolian and Manchu literary language*. Ulaanbaatar: Printing house of the Academy of Sciences]

Төмөртоогоо, Д. (2022). Түүхэн хэл зүй. *Монгол хэл судлал*. V. Ред. Д.Заяабаатар. Улаанбаатар. Х. 333-340. [Tumurtugoo, D. (2022). Historical grammar. *Mongolian language studies*. V. Ed. Zayabaatar D. Ulaanbaatar. P. 333-340.]

Товчилсон үг

МҮQ:	Manju yargiyan qooli
Man.	Манж хэл
Mon.	Монгол хэл
Chin.	Хятад хэл



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.